

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2019 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ТОВЧ МЭДЭЭ

1. Удирдлага, зохион байгуулалтын талаар

Орхон аймгийн Засаг дарга Д.Батлут БНХАУ-ын Манжуур хотын намын хорооны дарга Дү Лян Хэ тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Орхон аймаг Манжуур хоттой 2019-2020 хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа. Эрдэнэт хот нь Манжуур хоттой 2014 оноос эхлэн хамтран ажиллаж байгаа бөгөөд энэ хугацаанд төрийн захиргааны байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдийн засаг худалдаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хүмүүнлэгийн чиглэлийн хамтын ажиллагааг идэвхижүүлэх чиглэлээр хамтран ажилласан юм.

Мөн Орхон аймаг БНСУ-ын Дэгү хоттой эрүүл мэндийн аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Дэгү хот нь Солонгос улсдаа эрүүл мэндийн салбар хамгийн өндөр хөгжсөн бүс нутагт тооцогддог. Тус хоттой хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурснаар эрүүл мэндийн технологийн салбарт нягт хамтран ажиллаж, мэдээлэл солилцох, Эрдэнэт хотын эмч эмнэлгийн ажилтнуудыг БНСУ-д чадавхжуулах урт, богино хугацааны сургалт зохион байгуулах, эрүүл мэндийн аялал жуулчлалыг дэмжин ажиллах юм.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт “Иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах” төвд биечлэн, цахимаар болон утсаар 24 цагийн туршид иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэлтийн талаар 7 хоног тутамд аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулан холбогдох албан тушаалтанд үүрэг даалгаврыг өгч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

4-р сард хуралдсан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар:

1. “Орхон аймгийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” батлах тухай

2. Нүхэн жорлонгоо өөрчилж, стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламж барьсан гэр хорооллын иргэдэд урамшуулал олгох журмын тухай

3. “Хашаандаа хаус”, “Явган зам” дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

4. “Хотын доторх замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттай оролцуулах түр зөвшөөрөл олгох журам”-ын биелэлтийн талаар

5. Баян-Өндөр сумын ЗДТГ-т иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх товч мэдээлэл

6. Эрүүл мэндийн газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх товч мэдээлэл

7. Эрдэнэт хотын 2019-2020 оны өвөлжилт болон хөдөө аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний талаар

8. Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2018 оны төлөвлөгөөний биелэлтийн талаарх асуудлуудыг хэлэлцэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч ажиллаж байна.

2. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд

4 дүгээр сарын байдлаар аймгийн төсөвт 30.6 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 105.5 хувьтай байна. Татварын бус орлогын төлөвлөгөө 3.1 хувиар тасарч, татварын орлого 13.5 хувиар давж биелсэн байна. Орон нутгийн төсвөөс төлөвлөгөөт санхүүжилтийн 55.0 хувийг буюу 24.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 5.5 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 8.0 хувийг хөрөнгийн зардалд, 13.9 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 28.6 хувийг бараа үйлчилгээний зардалд, 44.0 хувийг цалин хөлсөнд зарцуулжээ. Салбарын хувьд эдийн засгийн бусад салбарт 0.9 хувийг, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн салбарт 1.8 хувийг, эрүүл мэнд, амралт спортын салбарт 2.8 хувийг, ангилагдаагүй бусад зардалд 8.0 хувийг, нийтийн ерөнхий үйлчилгээнд 41.5 хувийг, боловсрол, соёл урлагийн салбарт 45.0 хувийг зарцуулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт зарлага санхүүжилт 9.4 хувиар, орлого 9.8 хувиар нэмэгджээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 38.1 тэрбум төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 57.3 хувиар давж биелсэн байна. Эрүүл мэндийн даатгал, ҮОМШӨ, ажилгүйдэл, тэтгэмж, тэтгэврийн сангийн орлогын төлөвлөгөө 17.0-76.9 хувиар давж биелжээ. Сангийн нийт орлого өмнөх оны мөн үеэс 52.2 хувиар буюу 13.9 тэрбум төгрөгөөр их байна.

3. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд

Орхон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдийн оролцоо, эцэг эх, багш нийгмийн ажилтны хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Өсвөрийн сэргийлэгч 2019” тэмцээнийг аймгийн ГХУСАЗСЗ, аймгийн Цагдаагийн газартай хамтран зохион байгууллаа. Энэхүү тэмцээн нь сургууль, гэр бүлийн орчинд үйлдэгдэж болзошгүй

гэмт хэрэг, зөрчлөөс хэрхэн сэргийлэх, сурагчдын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, Орхон аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмүүд харилцан бие биенээсээ туршлага судлах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Цагдаагийн газрын мэдээгээр 4 дүгээр сард 229 хэрэгт 113 хүн холбогдон шалгагдаж, хэргийн илрүүлэлт 47.0 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс хэргийн илрүүлэлт 9.7 пунктээр өсч, холбогдогч 33.5 хувиар, бүртгэгдсэн хэрэг 25.9 хувиар, 18–аас дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 11.9 процицимилээр буурчээ. Гэмт хэргийн улмаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 962.4 сая төгрөгийн хохирол учирсан ба нийт хохирлын 39.6 хувийг нь нөхөн төлүүлсэн байна. Өмнөх оны мөн хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг хэрэг 2.3 дахин нэмэгдэж, хүн амины хэрэг өмнөх оны мөн үеийн түвшинд байж, бусад хэргийн гаралт 12.887.5 хувиар буурснаас дээрэмдэх хэрэг 87.5 хувиар буурчээ. Гэмт хэрэгт холбогдсон 113 хүний 5.3 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 65.5 хувь нь эрхэлсэн тодорхой ажилгүй, 58.4 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцож байсан 537 жолоочийг илрүүлэн, зөрчил гаргасан 448 жолоочийн эрхийг тодорхой хугацаагаар хасч шийтгэжээ. Өмнөх оны мөн үеэс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөнд оролцсон жолоочийн тоо 8.8 хувиар, эрх хасалт 3.2 хувиар буурчээ.

4. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд

Газар зүйн улсын 25 дугаар олимпиадыг Орхон аймагт зохион байгуулж аймаг, нийслэлээс шалгарсан 60 гаруй багш, сурагчид оролцсон.

Мөн хүүхэд бүрийг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлж, хүүхдийн авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын нэрэмжит хүүхдийн урлагийн “Яргуй” наадмыг 20 дахь жилдээ зохион байгуулж, 700 гаруй хүүхэд 7 төрлөөр оролцож авъяас чадвараа сорьсон байна.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим эмч, эмнэлгийн ажилтнуудад төрийн болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын нэрэмжит шагнал гардуулах арга хэмжээг зохион байгууллаа.

4 дүгээр сарын байдлаар эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 209.8 мянган хүнд үзлэг хийснээс 36.5 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна. Өмнөх оны мөн үеэс нийт үзлэг 1.2 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 2.5 хувиар нэмэгджээ. Сэргийлэх тарилгад нийт хамрагдвал зохих хүний 99.4 хувь буюу 5.7 мянган хүн хамрагдсан ба хамрагдалт өмнөх оны мөн үеэс 1.4

пунктээр их байна. Эрүүл мэндийн газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 859 эх амаржиж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.7 промилээр буурчээ.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жил, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, нийгмийн халамжийн чиглэлээр 300 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

Тайлант хугацаанд нийт 632 ажлын байр бий болсны 46.8 хувь нь шинэ ажлын байр байна. Нийт ажлын байрны 10.3 хувь нь худалдааны салбарт, 12.2 хувь нь зочид буудал, зоогийн газарт, 20.9 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт, 21.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 35.4 хувь нь бусад салбарт бий болжээ. Өмнөх оны мөн үеэс нийт бий болсон ажлын байр 60.8 хувиар, шинээр бий болсон ажлын байр 28.1 хувиар нэмэгджээ.

Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо, Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран “Эрүүл аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө” уриан дор сарын аян 8 дахь жилдээ зохион байгууллаа. Орхон аймгийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлөөс “Эрүүл аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө” сэдэвт онол, практикийн сургалтыг зохион байгуулж, нийт байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулав.

Аэробик гимнастикийн өсвөрийн улсын аварга шалгаруулах 15 дахь удаагийн тэмцээн 4-р сарын 15, 16-ны өдрүүдэд Орхон аймагт амжилттай болж төв, орон нутгаас шалгарсан 16 багийн 200 гаруй тамирчид ур чадвараараа өрсөлдсөн.

5. Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Оны эхний төллөх эх малын 55.7 хувь буюу 30.7 мянган хээлтэгч мал төллөж, гарсан төлийн 99.9 хувь нь бойжиж байна. Өмнөх оны мөн үеэс төллөлт 16.3 пунктээр их, төлийн хорогдол 94.2 хувиар бага байна.

Баян-Өндөр сумын төллөх эх малын 52.6 хувь, Жаргалант сумын төллөх эх малын 58.2 нь төллөж, гарсан төлийн 99.7-99.99 хувь нь бойжиж байна. Тайлант хугацаанд 110 толгой том мал зүй бусаар хорогдож, мал онд оролт 99.9 хувьтай байна. Өмнөх оны мөн үеэс мал онд оролт 3.8 пунктээр их, малын хорогдол 97.7 хувиар бага байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зөвлөгөөнд 420 гаруй иргэн, аж ахуйн нэгж, малчин, тариаланч, малын эмч, салбарын мэргэжилтнүүд

хамрагдлаа. Баян-Өндөр, Жаргалант суманд үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн удирдлагуудад мал эмнэлгийн салбарын зорилт, хууль, эрх зүйн талаар мэдлэг олгох сургалтыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгтэй хамтран зохион байгуулав.

Аймгийн хүн амын хаврын махны хэрэгцээнд үхэр, хонь, ямааны мах нийт 300 тонн махыг худалдаанд гаргахаар Эрдмийт ХХК-тай гэрээг байгуулж, 3 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн худалдаанд гаргаж эхлээд байна. 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар 1 кг үхрийн мах 7700 төгрөг, хонины мах 7200 төгрөг, ямааны махыг 6300 төгрөгөөр үхрийн мах 40.7 тн, хонины мах 62.6 тн, ямааны мах 15.4 тн буюу нийт 118.8 тонн махыг төвлөрсөн 6 цэгээр худалдан борлуулсан байна.

6. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Байгаль цаг агаарын хувьд сарын дундаж температур 4.2 хэмийн дулаан байж, өмнөх оны мөн үеэс 0.1 хэмээр хүйтэн, хур тунадас 10.5 мм-ээр бага байна. Агаарын чанарын MNS4585:2016 стандартад харьцуулан үзэхэд хүхэрлэг хий (SO₂), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын давхар исэл (NO₂) стандартаас даваагүй байна.

Орхон аймгийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зорилготой “Эдийн засгийн форум 2019” арга хэмжээг зохион байгуулав. Чуулганаар Бүсчилсэн хөгжлийн болон орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлт, хүн амын нутагшил, суурьшлын талаар, Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2025” бодлогын баримт бичгээ олон нийтэд танилцуулсны зэрэгцээ “Нийгмийн тогтвортой хөгжил”, “Эдийн засгийн тогтвортой хөгжил”, “Байгаль орчны тогтвортой хөгжил”, “Засаглалын тогтвортой хөгжил” сэдэвт салбар хуралдаануудад эрдэмтэн судлаачдын 20 гаруй илтгэлийг хэлэлцлээ. Чуулганд ОХУ, БНХАУ, БНСВУ-ын Элчин сайдын яам болон НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн банк, Европын сэргээн босголтын банк, Жайка олон улсын байгууллага, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн төлөөлөл оролцсон бөгөөд ЗГХЭГ-ын Орон нутгийн удирдлага, зохицуулалтын газрын дарга П.Энхсайхан, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, ОХУ-ын Худалдааны төлөөлөгч М.В.Васильев, БНХАУ-ын ЭСЯ-ны эдийн засаг, худалдааны зөвлөх Сүн Шүэ Жүн, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “ЭТИС” хөтөлбөрийн захирал, доктор Карин Райнпрехт нар мэндчилгээ дэвшүүллээ.

Аж үйлдвэрийн салбарт 743.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, 749.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулж, өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлт 7.8 хувиар, борлуулалт 13.2 хувиар буурсан байна. Их барилгын салбарт 13 аж ахуй нэгж 12.1 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 18 объектод хийж гүйцэтгэсний 19.8 хувь нь их засварын ажил байна. Гүйцэтгэсэн ажлын дүн өмнөх оны мөн үеэс 5.8 дахин нэмэгджээ.

Өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 13.9 хувиар, тээсэн зорчигч 7.8 хувиар, зорчигч эргэлт 7.5 хувиар буурч, харин ачаа эргэлт 4.6 хувиар нэмэгджээ. Зорчигч тээврийн үйлчилгээнд 442 такси, 5 микроавтобус, 70 автобус гарч, тэдгээрт 765 хүн ажиллаж байна.